



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 30 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 27¹.1.9 дэх заалт нэмсүгэй:

“27¹.1.9.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлах.”

2 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “шилжүүлэх” гэсний дараа “, хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.2 дахь хэсгийн “27¹.1.1, 27¹.1.2, 27¹.1.3, 27¹.1.4, 27¹.1.5, 27¹.1.6, 27¹.1.7-д” гэснийг “27¹.1.1, 27¹.1.2, 27¹.1.3, 27¹.1.4, 27¹.1.5, 27¹.1.6, 27¹.1.7, 27¹.1.8-д” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР